



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

“ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ
БУЙ БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

Хүүхэд хамгааллын бодлогыг орон нутгийн түвшинд үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжүүлсэн ч мэргэжлийн байгууллага хууль, журамд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Аудитын код: ДГА-2024/20-8-ШТА-ГА

Цахим хуудас:
www.audit.mn

Дорноговь аймаг
2024 оны 10 сар

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Аудитын менежер:

Утас: 70523020

Ахлах аудитор:

Аудитор:

Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

У.Оюунтүлхүүр

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

О.Нарангарав

Цахим хаяг: narangarav.o@audit.gov.mn

М.Дүүрэнжаргал

Цахим хаяг: duurenjargalm@audit.gov.mn

Н.Мөнхнасан

Цахим хаяг: munkhnasann@audit.gov.mn

А.Дамчой

Цахим хаяг: damchoia@audit.gov.mn

БҮЛЭГ 1. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО ЧИГЛЭЛИЙГ ОРОН НУТГИЙН БОДЛОГОД ТУСГАЖ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАН АЖИЛЛАСАН БАЙНА.

1.1. АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ДУНД БОЛОН БОГИНО ХУГАЦААНЫ БАРИМТ БИЧИГТ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААРХ АРГА ХЭМЖЭЭГ ТУСГАН ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.

1. Аймгийн ИТХ-ын 2020 оны 02/05 дугаар тогтоолоор баталсан “Дорноговь аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл”-ийн 2-т заасан “Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийг хангах зорилго”-ын хүрээнд хүүхэд хамгаалалтай холбоотой 3 зорилтын 5 үйл ажиллагааг, 3-т зассан “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг дээшлүүлэх зорилго”-ын хүрээнд 1 зорилтын 1 үйл ажиллагааг, 7-д заасан “Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангах зорилго”-ын хүрээнд 1 зорилтын хүрээнд 2 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тус тус тусгасан

Аймгийн ИТХ-ын 2020 оны 02/63 дугаар тогтоолоор баталсан “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 2020-2024”-т хүүхэд хамгааллын талаар 3 зорилгын 8 зорилтын 14 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Аудитын хамрагдсан хугацаанд Дорноговь аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн (2020-2024) хэрэгжилтийг үйл ажиллагаа тус бүрээр үнэлж дүгнэсэн байна.

Хүснэгт: Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгийн хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээнд өгсөн үнэлгээ

№	Хөгжлийн богино, дунд хугацааны бодлогын баримт бичиг	Үнэлгээ, дүгнэлт
1	Аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт	2023 оны 12 дүгээр сарын 05-ны 15/02 дугаар тогтоолоор хүүхэд хамгааллын чиглэрээх 8 үйл ажиллагааны үнэлгээ дунджаар 88 хувь
2	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024)-ийн хэрэгжилт	2023 оны 12 дүгээр сарын 05-ны 15/02 дугаар тогтоолоор хүүхэд хамгааллын чиглэрээх 14 үйл ажиллагааны үнэлгээ дунджаар 95 хувь

Эх сурвалж нь: Аймгийн үндсэн чиглэл, үйл ажиллагааны тайлан

Дорноговь аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтээс хүүхэд хамгаалалтай холбоотой үйл ажиллагааг авч үзвэл:

- Иргэдийн оршин суух газар, зам талбайн 98 байршилд камержуулалт байснаас шинээр 110 байршилд хяналтын камер, нийт 9 сумын аж ахуйн нэгж, байгууллагууд 260 гаруй хяналтын камерыг тус тус шинээр нэмэгдүүлсэн.
- “Түр хамгаалах байрны үйлчилгээ үзүүлэх журам”-ын дагуу 2 түр хамгаалах байранд 2019-2023 онд бие мах бодийн, бэлгийн, үл хайхрах, гэр бүлийн, сэтгэл санааны гэх мэт хүчирхийлэлд өртсөн насанд хүрсэн 40, насанд хүрээгүй 178 нийт 218 хохирогчийг хүлээн авч, үйлчлүүлэгчид үзүүлэх суурь үйлчилгээ үзүүлэн холбон зуучлах болон гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээнүүдийг үзүүлсэн. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 92.6 хувьтай байна.

- Сайншанд сумын 8 багийн эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа болон хагас, бүтэн өнчин хүүхэдтэй нийт 150 өрхөд цахилгааны аюулгүй байдал, галын аюулгүй байдал бохирын нүх, хүнс тэжээлийн нөөц зэрэгт нөхцөл байдлын үнэлгээг хийж, эрсдэлтэй гарсан нийт 33 өрхөд хүнсний болон бусад дэмжлэг, хариу үйлчилгээ үзүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2020-2024/-ийн хэрэгжилтээс:

- Аймгийн хэмжээнд 2020-2023 оны байдлаар Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх 230 гаруй нэр төрлийн хэсэгчилсэн арга хэмжээ, сургалт, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулж давхардсан тоогоор 64,024 гаруй иргэдийн хамруулсан байна.
- Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх танхимыг 2023 онд тохижуулан, иргэд олон нийт, хүүхэд ганцаарчилсан зөвлөгөөг өгөхийн зэрэгцээ мэргэжилтнүүд болон Хамтарсан багийн нийгмийн ажилтнуудын зүгээс насанд хүрээгүй 31, насанд хүрсэн 1, 3 гэр бүлд тулгамдсан асуудлыг нь шийдвэрлэх, сэтгэл зүйн анхан шатны үйлчилгээг үзүүлсэн байна.
- Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг аймгийн Гэр бүлийн талбайд зохион байгуулж эцэг, эх, асран хамгаалагч, хүүхэд багачуудад “Хүүхэд хамгааллын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга, хүүхдийн тусламжийн 108 утасны мэдээллийг өгч ажилласан.
- Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, хүүхдээ болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй орчинд амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Миний гэр аюулгүй орчин” гэрийн аюулгүй байдлыг үнэлэх үнэлгээг 56 иргэнийг хамруулж, эрсдэлийг засах арга хэмжээг авч ажилласан байна.
- Аймгийн хэмжээнд 120 байгууллага эцэг эхийн зөвлөлийг байгуулан, 56 байгууллага Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичигтэй болсон байна.

2. Аймгийн хэмжээнд 2019-2023 оны хооронд хүүхэд хамгааллын чиглэлээр дараах дэд хөтөлбөрүүд батлагдсан байна. Үүнд:

- Аймгийн ИТХ-ын 2019 оны 68 дугаар тогтоолоор “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх (2019-2023)”,
- Аймгийн ИТХ-ын 2019 оны 69 дүгээр тогтоолоор “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх (2019-2023)”,
- Аймгийн ИТХ-ын 2021 оны 53 дугаар тогтоолоор “Хүүхдэд ээлтэй орон нутаг (2021-2024)”

Аудитын хамрагдах хугацаанд 2 дэд хөтөлбөр хэрэгжиж дууссан, 1 зорилтод дэд хөтөлбөрийн хэрэгжилт бүрэн хангагдсан, хөтөлбөр бүрийн хэрэгжилтийг жил бүр өссөн дүнгээр тайлагнаж, аймгийн ИТХ-аар дүгнүүлсэн байна.

Хүснэгт: Хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үнэлгээ

№	Хөгжлийн богино, дунд хугацааны бодлогын баримт бичиг	Үнэлгээ, дүгнэлт
1	“Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх” дэд хөтөлбөр /2019-2023/ хэрэгжилт	2023 оны 12 дүгээр сарын 05-ны 15/02 дугаар тогтоолоор 86.1 хувь
2	“Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” дэд хөтөлбөр /2019-2023/-ийн хэрэгжилт	2023 оны 12 дүгээр сарын 05-ны 15/02 дугаар тогтоолоор 92.5 хувь
3	“Хүүхдэд ээлтэй орон нутаг” зорилтод хөтөлбөр /2021-2024/-ийн хэрэгжилт	2023 оны 12 дүгээр сарын 05-ны 15/02 дугаар тогтоолоор 86.9 хувь

Эдгээр хөтөлбөрүүд хэрэгжсэнээр аймгийн хэмжээнд хүүхдийн хөгжил оролцоог нэмэгдүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр үндэсний болон орон нутгийн хэмжээнд соёл, спортын уралдаан тэмцээн, сургалт, хэлэлцүүлэг, аяны арга хэмжээ зэргийг зохион

байгуулсан байна. Аймгийн Засаг даргын 2022 оны А/95 дугаар захирамжаар 2022 оныг “Хүүхэд хөгжил-2022” зорилтот жил болгон, тус зорилтот жилийн хүрээнд Хүүхдийн ордныг хүүхдийн дугуйлан секц явуулах чиглэлээр “Хүүхэд хөгжлийн төв” болгож, давхардсан тоогоор 1500 гаруй хүүхэд хамрагдсан байна.

1.2. АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР БОДЛОГО БОЛОВСРУУЛАН ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА БОЛОВЧ ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ЗӨВЛӨЛ ОРОН НУТГИЙН БОДЛОГОТОЙ УЯЛДУУЛАН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨЛӨВЛӨЖ, ТАЙЛАГНАХ АЖИЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

1. Аймгийн Засаг даргын 2017 оны А/168 дугаар захирамжаар байгуулагдсан хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүдийг 2022 оны А/196 дугаар захирамжаар шинэчилсэн бөгөөд зөвлөл нь аймгийн Засаг даргаар ахлуулсан, хэлтсийн дарга 2, төсөвт байгууллагын дарга 8, олон нийтийн болон ТББ-ын 3 төлөөлөл оролцсон нийт 14 хүний бүрэлдэхүүнтэйгээр баталсан байна.

Тус захирамжид аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл нь аймгийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэл зэрэгт тулгуурлан жил бүр үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг хэлэлцэн баталж, зөвлөлийн гишүүд салбар бүрд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан мэдээг аймгийн ХГБХХГ-т хүргүүлэн ажиллахаар заасан байна.

Аймгийн ХГБХХГ нь чиг үүргийн дагуу хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүн байгууллагуудаас ирүүлсэн санал, хэрэгжилтийн тайланг авч, төлөвлөгөөг боловсруулан, тайланг нэгтгэн гаргадаг байна.

Хүснэгт: Аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн төлөвлөгөө, хэрэгжилтийн мэдээлэл

Он	Хүүхдийн төлөө зөвлөл хуралдсан эсэх / огноо	Төлөвлөгөө баталсан огноо	Хэрэгжилтийн тайлан гарсан огноо	Нийт төлөвлөсөн арга хэмжээний тоо	Үүнээс: хүүхэд хамгааллын арга хэмжээний тоо	Хүүхэд хамгааллын арга хэмжээний эзлэх хувь
2019	Тийм / 2019.07.19	2019.02.28	2019.12.24	24	12	50%
2020	Үгүй	-	-	10	5	50%
2021	-	-	-	-	-	-
2022	Тийм / 2022.05.11	2022.05.26	2022.12.28	15	8	53.3%
2023	Үгүй	-	2023.12.25	-	-	-

Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын архивын нэгжийн баримт

Дээрх мэдээллээс харахад аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн 2019-2023 оны 5 жилийн хугацаанд 2 удаа хуралдаж, төлөвлөгөө баталсан, 3 удаагийн тайлан 12 дугаар сарын сүүлээр гарсан, батлагдсан төлөвлөгөөний 50 хувь нь хүүхэд хамгааллын чиглэлээрх арга хэмжээ байна.

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны тайланд Зөвлөлийн хурлыг 7 дугаар сарын 19-ний өдөр хийж, төлөвлөгөө баталсан гэж тайлагнасан. Гэтэл тус баталсан төлөвлөгөөний огноо нь 2 дугаар сарын 28-ны өдрөөр, холбогдох байгууллагуудаас төлөвлөгөөнд тусгах санал ирүүлэх албан бичгийг 2019 оны 4 дүгээр сард явуулсан байгаа нь цаг хугацааны хувьд уялдахгүй байна.

Мөн 2023 оны хувьд зөвлөл хуралдаагүй, төлөвлөгөө боловсруулаагүй байтал, оны сүүлд аймгийн Засаг даргын 2023 онд хүүхдийн эрх хамгааллын чиглэлээр гаргасан 2 захирамж, 1 албан даалгаврын хэрэгжилтийн тайланг зөвлөлийн тайлан болгон гаргасан байна. Харин 2020, 2021 онуудын хувьд гарсан төлөвлөгөө /2020 оны хувьд төлөвлөгөөний төсөл байсан/, хэрэгжүүлсэн тайланг нотолсон баримт байхгүй бөгөөд аудит хийх хугацаанд аймгийн ХГБХХГ-ын холбогдох мэргэжилтнүүдээс архивын нэгж байгаа эсэх, эдгээр

онуудад төлөвлөгөө, тайлан гарсан талаар тодруулахад хангалттай нотолгоо баримт ирүүлээгүй болно.

Дээрхээс дүгнэж үзэхэд 2019-2023 онуудад орон нутгийн бодлогын түвшинд хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр хангалттай арга хэмжээ зохион байгуулж ажилласан боловч аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл нь Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-т заасан чиг үүргийн дагуу тайлант онуудад хийх арга хэмжээг төлөвлөж, тайлагнах ажил нь хангалтгүй хийгдсэн байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн /2016 онд батлагдсан/ 21 дүгээр зүйлийн 21.2-т “... орон нутгийн зөвлөл жил бүрийн 3 дугаар улиралд багтаан хүүхэд хамгааллын тайлан гаргаж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар төрийн захиргааны байгууллагад чиглэл, нутгийн өөрөө удирдах байгууллага, холбогдох бусад байгууллагад зөвлөмж өгч, бодлого тодорхойлох, шийдвэр гаргах эрх бүхий оролцогч талуудад санал оруулна”, 21.3-т “Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан өөрийн нутаг дэвсгэр дэх хүүхэд хамгааллын талаар тухайн шатны хүүхдийн төлөө зөвлөлийн тайлан, Засаг даргын саналыг хэлэлцэж, орон нутгийн төсөвт тусган, хэрэгжүүлэх арга хэмжээг авна” гэж тус тус заасан байна.

Гэтэл аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн төлөвлөгөөний хэрэгжилт 12-р сард тайлагнаж байгаа нь хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар төрийн захиргааны байгууллагад чиглэл, холбогдох бусад байгууллагад зөвлөмж өгөх, нутгийн өөрөө удирдах байгууллага, болон бодлого тодорхойлох, шийдвэр гаргах эрх бүхий оролцогч талуудад санал оруулах ажлууд хэрэгжих боломжгүй, байгууллага хоорондын уялдаа холбоо хангалтгүй байна.

2. Аймгийн засаг дарга ХНХ-ын сайдтай байгуулсан гэрээ, аймгийн бодлогын баримт бичгүүд, дэд хөтөлбөрүүдэд тусгагдсан үйл ажиллагаанаас аймгийн ХГБХХГ-ын нь жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд орон нутгийн нөхцөл байдалтай уялдуулан хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх ажлуудыг төлөвлөн, хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээг хийж биелэлтийг тооцон тайлагнасан байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт арга хэмжээнд хүүхэд хамгааллын талаар дунджаар 37.8 хувь буюу 15 арга хэмжээг тусган хэрэгжүүлэн ажилласан нь төлөвлөсөн ажлын 1/3 нь хүүхэд хамгааллын чиглэлээрх үлдсэн 2/3 нь хүүхдийн хөгжил, залуучууд, гэр бүлд чиглэсэн ажил, дотоод үйл ажиллагаа болох хүний нөөц, санхүү, архив бичиг хэрэг, сургалт зэрэг чиглэлийн арга хэмжээнүүд тусгагддаг байна.

Аймгийн хэмжээнд 14 сумын нийт 27 хүүхэд хамгааллын хамтарсан багтай бөгөөд баг нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10, 11, 12, 13, 14, 15, 16 дугаар зүйл болон 17.1.4 дэх заалтын дагуу нийгмийн бүх орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчил, эрсдэлд нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүлээн авах, илрүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийт хамтарсан багуудаас түүвэрлэн 10 хамтарсан багийн үйл ажиллагаанд “Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам¹”-ын шаардлагуудыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа эсэхэд ярилцлага хийхэд дараах асуудлуудад арга хэмжээ авч ажиллах талаар санал болгосон Үүнд:

1. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл арга зүйн дэмжлэг үзүүлэх.
2. Хүүхдийн эрхийн улсын байцаагч багийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг тавих
3. Үйлчлүүлэгчийн хувийн хэргийн нууцлалыг хадгалах нөхцөл бүрдүүлэх

¹ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн хамтарсан тушаал

4. Хамтарсан багийн үйл ажиллагааны төсвийг сумын ИТХ-аар баталж, санхүүжүүлэх.²

Сайншанд сумын хамтарсан багаас бусад сумдын хамтарсан багт **КЕЙС МЕНЕЖЕР БУЮУ НИЙГМИЙН АЖИЛТАН**-ы орон тоо байхгүй байгаа³ нь кейс менежментийн үйл явцыг хянаж, удирдах чиг үүргийг орхигдуулах эрсдэлтэй байна.

3. Хүүхдийн хамгааллын талаарх мэдээллийг 2019-2021 онуудад ABLE системээр, 2022-2023 онуудад НАМС-ээр, (дахин нэвтрэх боломжгүй бөгөөд тус онуудын мэдээллийн сан байхгүй) 2024 онд дахин ABLE системээр дамжуулан сан бүрдүүлсэн байна.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын мэдээллийн сан бүрдүүлэх ABLE программд уралдаанч хүүхэд, асрамж халамжийн төв, хүүхэд харах үйлчилгээ, эрсдэлт нөхцөл дэх хүүхэд, зусланд амарсан хүүхдийн мэдээллийг бүртгэхээс хурдан морь унаач хүүхдийн бүртгэлийг тогтмол мэдээлж хэвшсэн байна.

НАМС программын ашиглагдаж байх хугацаанд сумдын хамтарсан багийн нийгмийн ажилтан нөхцөл байдлын үнэлгээний дүнг бүртгэсэн байна. Бүртгэлээр аймгийн хэмжээнд 1,352 өрхийн 20,431 хүнийг нөхцөл байдлын үнэлгээнд хамруулан үүнээс 60 кейс менежментийг хийж хариу арга хэмжээг үзүүлэн бүртгэсэн боловч программд дахин нэвтрэх боломжгүйгээс мэдээллийг цаашид ашиглах боломжгүй болсон байна.

Мэдээллийн нэгдсэн сан бүрэлдээгүйгээс салбар хоорондын тоон мэдээллүүд зөрүүтэй тайлагнагдаж байна. Тухайлбал эрсдэлд бүлэгт байгаа хүүхдийн тоо мэдээлэл ХГБХХЕГ болон аймгийн ХГБХХГ-ын тоон мэдээлэл зөрүүтэй байгаа тул аудитын тайланд аймгийн ХГБХХГ-ын баталгаажуулан гаргаж ирүүлсэн тоон мэдээг үндэслэл болгон ажиллав.

Хүснэгт: Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийн тоон мэдээлэл

Он	Аймгийн ХГБХХГ-аас ирүүлсэн эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийн тоон мэдээлэл	ХГБХХЕГ-ас ирүүлсэн эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийн тоон мэдээлэл	Зөрүүтэй тоон мэдээлэл
2019	645	875	230
2020	650	672	22
2021	686	631	(55)
2022	644	672	28
2023	672	672	0

Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын статистик мэдээ болон ХГБХХЕГ-аас ирүүлсэн мэдээлэл

Дээрх хүснэгтээс харахад ХГБХХЕГ-т хүргүүлсэн эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоон мэдээллээс 2023 оны мэдээлэл таарч, бусад онуудын хувьд аймгийн хамтарсан багуудын хүүхдийн нөхцөл байдлын үнэлгээгээр гаргасан мэдээнээс зөрүүтэй байгаа нь холбогдох байгууллагын хариуцлагагүй байдлаас шалтгаалсан байна.

ХГБХХГ-ын салбарын хэмжээнд хүүхэд хамгааллын талаарх үйл ажиллагааны мэдээллийн систем нь тогтворжоогүй, үүсгэсэн мэдээллээ цаашид ашиглах боломжгүй болсон зэргээс харахад аймаг, орон нутаг, улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх шаардлагатай байна.

4. Аймгийн ХГБХХГ-ын бүтэц орон тоог 2019-2023 онд 3 удаа шинэчилсний 2 нь аймгийн Засаг даргын захирамжаар, 1 нь ГБХЗХГ-ын даргын тушаалаар тус тус баталсан байна.

Байгууллагын орон тоо 2023 оны байдлаар 26 байхаар батлагдсан боловч гүйцэтгэлээр 24 орон тоотой буюу 2 орон тоотой дутуу ажилласан байна

² Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т заасны дагуу хэлэлцэн батална

³ Хүүхэд хамгааллын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага нь нутгийн өөрөө удирдах байгууллагатай зөвшилцөн сум, баг, дүүрэг, хороонд хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан ажиллуулна” гэж заасан байна.

Байгууллагын батлагдсан орон тоогоос хүүхдийн эрхийн асуудал хариуцсан 7 орон тоо байхаас өнөөдрийн байдлаар 2 орон тоо дутуу ажиллаж байна.

Аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу сул орон тоог нөхөх хүсэлтийг улирал бүр албан тоотоор хүргүүлсэн боловч, тухайн шалгаруулалтад орох хүн ирдэггүй, орсон хүн нь тусгай шалгалтдаа тэнцэхгүй байгаатай холбоотой байна.

Орон нутгийн хэмжээнд 5 сэтгэл зүйч мэргэжилтэн байгаа нь боловсролын салбарт ажиллаж байна.

Орон нутагт хүүхэд хамгааллын үйлчилгээг цогцоор нь үзүүлж, хүүхдийн эрх зөрчигдөх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахын тулд нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, гэр бүл судлаач гэх мэт мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх бодлого барьж, дэмжин тогтвор суурьшилтай ажиллах нийгмийн баталгааг хангаж хүний нөөцийг бүрдүүлэх асуудлыг бодлогын түвшинд авч үзэх шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨСВИЙГ ҮР ДҮНТЭЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙГЭЭС ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ ҮР ӨГӨӨЖТЭЙ БАЙЖ ЧАДАХГҮЙ БАЙНА.

2.1. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛААР ХҮҮХЭД ХӨГЖИЛ, ОРОЛЦООГ ХАНГАХ АЖЛЫГ САНХҮҮЖҮҮЛДГЭЭС ХҮҮХДИЙГ ЭРСДЭЛТ НӨХЦӨЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД НӨЛӨӨЛӨХҮЙЦ СУРГАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН АРГА ХЭМЖЭЭ БОЛЖ ЧАДАХГҮЙ БАЙНА.

1. Аймгийн ХГБХХГ нь 2019-2023 онуудад хүүхэд хамгааллын зардлын төсвийн төслийн саналыг боловсруулан хуулийн хугацаанд дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн ХГБХХГ-ын хүүхдийн эрх түүний үйл ажиллагаатай холбоотой гарах зардал нь 2019-2021 онуудад бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд нийт дүнгээрээ, харин 2022 оноос эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх, хамгаалах нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх гэсэн 3 хөтөлбөр зориулалтаар задлан баталдаг болсон байна.

Төсвийн төслийн хүргүүлсэн саналыг авч үзэхэд 2019-2022 онд хөтөлбөр зориулалтаар зардлыг задлан төлөвлөөгүй нь хүүхэд хамгааллын арга хэмжээнд хэдий хэмжээний зардлыг төсөвлөсөн нь тодорхой бус байна. Харин 2023 оны төсвийн саналаас эхлэн хөтөлбөр арга хэмжээ тус бүрээр төсвийн саналыг хүргүүлсэн байна.

Төсвийн төслийг боловсруулсан баримт материалтай танилцахад аймгийн эрсдэлд бүлгийн хүүхдийн тоо, өмнөх онд хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулсан хүүхдийн тоо, хэрэгжүүлсэн арга хэмжээ зэрэг тооцоо судалгаа хангалтгүй байгаа нь бодит тоо мэдээнд үндэслэн төлөвлөдөггүйг харуулж байна.

Хүүхэд хамгааллын үйл ажиллагааны зардлыг 2023 оноос хөтөлбөр, арга хэмжээгээр төлөвлөн, 2023 онд **170.8** сая төгрөгөөр төсвийн саналыг хүргүүлж 141.6 сая төгрөг буюу 28.4 сая төгрөгөөр бууруулж баталсан. Харин 2024 онд **147.0** сая төгрөгөөр буюу өмнөх оноос 23.8 сая төгрөгөөр бууруулан төлөвлөсөн байхад төсвийг **183.0** сая төгрөгөөр буюу төсвийн саналаас 36.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Хүүхэд хамгааллын зардлын төсвийн саналыг 2023 онд 170.8 сая төгрөгөөр хүргүүлсэн нь 2019 оноос 1.7 дахин өссөн, батлагдсан төсөв нь 2023 онд 141.2 сая төгрөг байгаа нь 2019 оноос 2.0 дахин өссөн үзүүлэлттэй байна.

2. Аймгийн ХГБХХГ-ын 2022, 2023 оны хүүхэд хамгааллын үйлчилгээний нийт төсвөөс дунджаар 34.2 хувийг урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн зардалд зарцуулахаар батлагдсан байна.

Зардлын гүйцэтгэлээр 2023 оны байдлаар урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардалд 28.6 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд тэмцээн уралдааны зардалд 9.4 сая төгрөг, албан томилолтын зардалд 1.5 сая төгрөг, шатахууны зардалд 1.2 сая төгрөг, үйлчилгээний төлбөр 12.3 сая төгрөг, сургалтын хэрэглэгдэхүүн, багшийн хөлс зэрэг бусад зардалд 4.1 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь хүүхдийг эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, эрхийг хамгаалах, сургалт, нөлөөллийн ажил, салбар дундын байгууллагуудын хүний нөөцийг чадавхжуулах, хамтарсан багийн сургалт болон бусад арга хэмжээнд зарцуулагдахгүй байгаа нь хүүхдийн эрхийн зөрчлийн шалтгааныг бууруулахад чиглэж чадахгүй байна.

Аймгийн ХГБХХГ-ын батлагдсан төсөвт хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих зардлын хөтөлбөр тусдаа батлаагүйгээс тухайн үйл ажиллагааны төсвөөс хүүхдийн хөгжил, оролцооны зардлыг гаргасан байна.

3. Аймгийн ХГБХХГ-т хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд улсын төсвийн санхүүжилтээс гадна байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан хүүхэд эмэгтэйчүүдийн аюулгүй байдлыг хангах түр хамгаалах байрны үйл ажиллагааг тасралтгүй явуулах зорилгоор шаардлагатай санхүүжилтийг жил бүр аймгийн орон нутгийн төсөвт тусган бүрэн санхүүжүүлэн ажилласан байна.

Аймгийн хэмжээнд хүн ам ихээр суурьшсан Сайншанд, Замын-Үүд сумдад түр хамгаалах байр ажилладаг бөгөөд 2019-2023 онд насанд хүрсэн 40, насанд хүрээгүй 178 хүн хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ авснаас эрсдэлт бүлгийн 178 хүүхэд нь хүүхэд хамгааллын цогц үйлчилгээг авсан байна.

Аудитын хамрах хугацаанд орон нутгийн төсвөөс ХНХ-ын сайдын 2020 оны А/150 дугаар тушаалаар батлагдсан “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардлын тооцох” журамд заасны дагуу зардлын санхүүжилтийг тооцон, нийт 174.1 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон байна. Тухайлбал: 2023 онд 54.5 сая төгрөгийг зарцуулснаас цалин хөлстэй холбоотой зардалд 40.6 сая төгрөг, тогтмол зардал 6.4 сая төгрөг, тээвэр шатахуун 1.7 сая төгрөг, хүнсний материал 3.3 сая төгрөг, аж ахуйн бараа материал 1.1 сая төгрөг, бусад зардалд 1.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Мөн “Намайг хамгаал” аяны хүрээнд Аймгийн Засаг даргын нөөцөөс 19.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, түр хамгаалах байрыг иж бүрэн камержуулсан байна.

2.2. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ИЛ ТОД БАЙДЛЫГ БҮРЭН ХАНГААГҮЙ, ХУВЬ ХҮНИЙ МЭДЭЭЛЛИЙГ НУУЦЛАХ АСУУДАЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

1. Байгууллагын 2019-2023 онд нийт батлагдсан төсөв 2,259.0 сая төгрөг бөгөөд 448.3 сая төгрөг буюу нийт зардлын 19.8 хувийг хүүхэд хамгааллын зардалд зарцуулахаар баталсан байна.

Аймгийн ХГБХХГ-ын 2019-2023 оны хүүхэд хамгааллын хөтөлбөр арга хэмжээний зардалд улсын төсвөөс нийт 448.3 сая төгрөгийн санхүүжилт олгож гүйцэтгэлээр 414.7 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтээр түр хамгаалахын байранд 174.1 сая төгрөгийг, 5 жилийн хугацаанд хүүхэд хамгаалах үйлчилгээнд улс, орон нутгийн төсвөөс нийт 588.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нийт зардлын 29.6 хувийг түр хамгаалах байрны үйл ажиллагаанд, 1.2 хувийг эрсдэл болон нөхцөл байдлын үнэлгээ хийх зардалд, 11.9 хувийг урьдчилан сэргийлэх, 57.3 хувийг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд тус тус зарцуулсан байна.

ХНХ-ын сайдын 2021 оны А/218 дугаар тушаалаар батлагдсан “Хүүхэд хамгаалах үйлчилгээ үзүүлэх” журмын 5 дугаар зүйлийн 5.1-т “Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх түвшний үйлчилгээ нь хүүхдэд чиглэсэн, эцэг эх, гэр бүлд чиглэсэн, олон нийтэд чиглэсэн, хүний нөөцийг чадавхжуулах сургалт, нөлөөллийн ажлаас бүрдэнэ” гэж заасны дагуу тухайн арга хэмжээнд чиглэсэн ажилд батлагдсан төсвийг зарцуулахаар байхад 2023 онд урьдчилсан сэргийлэх үйл ажиллагааны зардлаас аудитын төлбөр, санхүүгийн программын төлбөр, байгууллагын интернэтийн төлбөр төлөх зардалд зарцуулсан байна.

2. Аймгийн ХГБХХГ нь ил тод байдлыг хангаж байгууллагын төсөв хөрөнгийн зарцуулалтыг шилэн дансны цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах, албан хаагчдад танилцуулах зэргээр хүргэдэг байна.

Шилэн дансны цахим хуудсанд хүүхэд хамгааллын зардалтай холбоотой байршуулах мэдээллийг авч үзэхэд: 2019-2022 онуудад нийт 99.1 сая төгрөгийн орлогын, 135.2 сая төгрөгийн зардлын ажил гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй байна.

Харин байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг дутуу, хугацаа хоцроон байршуулсан 470.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хөргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. Үүнээс хүүхэд хамгааллын зардалтай холбоотой орлогын 199.8 сая төгрөгийн 17 ажил гүйлгээ, зарлагын 120.0 сая төгрөгийн 8 ажил гүйлгээг мэдээлэхээс орлого 54.6 сая төгрөгийн 2 мэдээлэл, зарлага 53.1 сая төгрөгийн 5 ажил гүйлгээг мэдээлээгүй байна.

3. Аудитын хамрах хугацаанд аймгийн ХГБХХГ-т хүүхэд хамгааллын чиглэлээр дараах төсөл, хөтөлбөр амжилттай хэрэгжиж холбогдох тайлан мэдээг хүргүүлсэн байна. Үүнд:

- Хууль зүйн дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банктэй хамтарсан Ядуурлыг бууруулах Японы сангийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжсэн “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслөөр түр хамгаалах байрны гадна орчныг тохижуулах, хашаажуулах үйл ажиллагаанд 14.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, төслийг бүрэн хэрэгжүүлэн тайланг хүргүүлсэн байна.
- НҮБ-ын Хүн амын сангаас 2021-2023 онуудад түр хамгаалах байраар үйлчлүүлэх хүүхэд, эмэгтэйчүүдийн аюулгүй байдал, амьдрах таатай орчин бүрдүүлэхэд нийт 16.4 сая төгрөгийн эмэгтэйчүүдийн иж бүрэн багц, хариу үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлсэн байна.

4. Аймгийн ХГБХХГ-ын дэргэдэх түр хамгаалах байранд гадны хүн нэвтэрсэн тухай бүртгэл байхгүй, урьдчилан зөвшөөрөл олгосон эсэх нь тодорхойгүй, байгууллагын болон гэрээт харуул хамгаалтын албан хаагчдаар нууцын баталгаа гаргуулан авч архивласан баримт нотолгоо тэмдэглэл байхгүй байна.

Аймгийн ХГБХХГ-ын мэргэжилтнүүд, түр хамгаалах байрны нийгмийн ажилтны болон хамтарсан багийн гишүүдийн гаргасан тайланд хамгаалах байраар үйлчлүүлж байгаа хүүхдийн зураг, эрсдэлт бүлэг, зорилтот бүлэг, хамгаалах болон нөхөн сэргээх, гэрийн эргэлт гэх мэт үйлчилгээ үзүүлсэн хэсгийг тайланд тусгахдаа хүүхэд болон иргэний зургийг ил тод, овог нэр гэх мэт мэдээллүүдийг оруулсан байгаа нь хувь хүний нууц бүрэн хамгаалагдаж чадахгүй байна.

5. Аймгийн хэмжээд 2023 оны байдлаар 0-18 насны нийт 26,844 хүүхэд бүртгэгдсэний эрсдэл бүлэгт нийт 672 хүүхэд бүртгэлтэй гэсэн судалгааг аймгийн ХГБХХГ-аас гаргасан байна. Мөн хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээг 325 хүүхдэд, урьдчилан сэргийлэх үйлчилгээг 10321 хүүхдэд, түр хамгаалах байранд 36 хүүхэд хамрагдсан тоон мэдээллийг гаргасан байна.

Аймгийн хэмжээд 2019-2023 онд хүүхэд хамгааллын цогц үйлчилгээг үзүүлсэн байдлыг авч үзвэл:

- Аймгийн 14 сумын 27 хамтарсан багийн гишүүдийн хийсэн судалгаагаар сүүлийн 5 жилийн дунджаар 742 хүүхдийг нөхцөл байдлын үнэлгээнд хамруулан 659 хүүхдийн эрсдэлд нөхцөлд амьдарч байгааг тодорхойлсон байна.
- Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээг давхардсан тоогоор нийт 1,314 хүүхдэд үзүүлснээс эрсдэлт бүлгийн 998 хүүхдийг хамруулсан байна.
- Урьдчилан сэргийлэх үйлчилгээг давхардсан тоогоор нийт 48,410 хүүхдэд үзүүлснээс эрсдэлт бүлгийн 1,358 хүүхдийг хамруулсан байна.
- Түр хамгаалах байрны үйлчилгээ авсан нийт 178 хүүхдээс 178 хүүхэд нь эрсдэлт бүлгийн хүүхэд байгаа нь зорилтод бүлгийн хүүхдүүдийг хамруулж чадсан байна.

Аймгийн хэмжээнд 2019-2023 онд бэлгийн хүчирхийлэлд 37 хүүхэд өртсөний хуулийн дагуу 30 хэрэг нь бүрэн шийдвэрлэгдэж хаагдаж, 7 хэрэг нь дараа онд шилжсэн байна. Эдгээр хүүхдүүдэд өмгөөллийн, нийгмийн, сэтгэл зүйн, эрх зүйн туслалцаа үзүүлэх гэх мэт үйлчилгээг үзүүлсэн байна.

БҮЛЭГ 3. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦООНЫ ГОЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛАГА БОЛОХ АЙМГИЙН ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.

3.1. ХУУЛИАР ХЯНАЛТ ТАВИХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУД ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ХИЙСЭН АРГА ХЭМЖЭЭНД ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

1. Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл 2019, 2022 онуудад үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан оролцогч байгууллагуудад хэрэгжилтийг ханган ажиллаж тайлан мэдээг хагас бүтэн жилээр гарган ирүүлэхийг үүрэг болгосон байна. Гэтэл хэрэгжилтийг тайлагнах 8 байгууллагаас 2019 онд 2 байгууллага, 2022 онд 5 байгууллага тус тус тайланг ирүүлсэн байна.

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавьсан талаар тайлан, нотлох баримт ирүүлээгүй.

2. Аймгийн ХГБХХГ-аас 2023 онд түр хамгаалах байрны үйл ажиллагаанд зөвлөн туслах, ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын бодлогын баримт бичиг түүний хэрэгжилтэд, хамтарсан багийн нөхцөл байдлын үнэлгээ хийх журмын хэрэгжилт, хариу үйлчилгээний үр дүн зэрэгт төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт хийж нийт 21 зөвлөмжийг хүргүүлсэн гэж тайлагнасан байна.

Гэтэл аймгийн ХГБХХГ нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, хяналт шинжилгээ-үнэлгээ хийсэн, зөвлөмж боловсруулсан, хүргүүлсэн, зөвлөмжийн хэрэгжилттэй холбоотой нотлох баримт байхгүй байна.

Мөн Хүүхэд хамгааллын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу хүүхэд хамгааллын нөхцөл байдлыг тодорхойлох, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлсэн хариу үйлчилгээг үнэлэх хяналт, шинжилгээ, үнэлгээг хийсэн ажилтай холбоотой баримт материал байхгүй байгаа нь 2019-2023 онуудад хүүхэд хамгааллын үйлчилгээний хяналт шинжилгээний ажлыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3. Хууль зүйн дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банкттай хамтран ядуурлыг бууруулах сангийн буцалтгүй тусламжаар санхүүжүүлсэн “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийг Сайншанд сумын түр хамгаалах байранд хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ХГБХХГ төслийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжүүлэгч байгууллагад хүргүүлсэн боловч төсөл хэрэгжүүлэгч байгууллагаас төслийн үр дүнг дүгнэсэн эсэх нь тодорхойгүй байна.

3.2 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР САЛБАР БҮР ТОДОРХОЙ АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА БОЛОВЧ ӨРГӨН ЦАР ХҮРЭЭГ ХАМАРЧ ЧАДАХГҮЙ БАЙНА

1. ЭЦЭГ, ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧДАД ЧИГЛЭСЭН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, НӨЛӨӨЛЛИЙН АРГА ХЭМЖЭЭГ НИЙГМИЙН БҮХИЙ Л ОРЧНООР ДАМЖУУЛАН ҮР ДҮНТЭЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ ЗОХИОН БАЙГУУЛАХАД АНХААРАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Дорноговь аймгийн хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар 21,543 өрхөд 26,844 хүүхэд өсөж торниж байна. Хүүхдийн тусламжийн 108 дуудлагын утасны бүртгэлд гэр бүлийн орчинд 2019-2023 онуудад нийт 333 дуудлага бүртгэгдэж, жилд дунджаар дуудлагын тоо 13 хувиар өссөөр байна.

Тус аудитаар 22 асуулга бүхий судалгааг 5 сегментээс статистик түүврийн аргаашиглан цахим хэлбэрээр авсан. Судалгаанд 14 сумын 868 сурагч хамрагдсан бөгөөд эрсдэлт нөхцөлд орсон тохиолдолд 78.7 хувь нь **ХАМГИЙН ТҮРҮҮНД ЭЦЭГ, ЭХДЭЭ ХАНДАНА** гэж хариулсан нь гэр бүлийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлогыг таниулан сурталчлах нь тус бодлогын хэрэгжилтэд хамгийн чухал нөлөөтэй нь харагдаж байна.

Асуулгаар дийлэнх эцэг, эх, асран хамгаалагч нь хүүхдийг үл хайхрах, дарамт, хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалах арга хэмжээг авдаг гэж үздэг боловч сурагчдын хувьд 24.4 хувь нь **ҮГҮЙ**, 10.8 хувь **ЗАРИМДАА** гэж хариулсан байна. Мөн нийт эцэг, эх, асран хамгаалагчдын 57.4 хувь нь гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаанд **ХАМРАГДААГҮЙ** гэсэн байна.

Иймээс эцэг, эх, асран хамгаалагчдад нийгмийн бүхий л орчноор дамжуулан мэдлэг, мэдээлэл, сургалтын арга хэмжээг зохион байгуулах нэн шаардлагатай гэж үзэж байна.

2. ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛЛЫН АСУУДЛААР БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖ САЙЖИРЧ БАЙГАА Ч МЭРГЭЖЛИЙН БОЛОВСОН ХҮЧНИЙ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Боловсролын салбарт хүүхэд хамгаалалттай холбогдсон харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг боловсронгуй болгох тал дээр хөтөлбөр, журмыг баталсан байна.

Аймгийн хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 22 сургууль, хүүхдийн 34 цэцэрлэг үйл ажиллагаагаа эрхэлж байгаа бөгөөд сургалтын байгууллагууд нь Хүүхэд хамгааллын бодлогын хүрээнд төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус төлөвлөгөөнд хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эцэг, эх, асран хамгаалагчдад сургалт зохион байгуулах, нөхцөл байдлын судалгаа хийх, шаардлагатай арга хэмжээг авах, сурагчдыг идэвхжүүлэх зэргээр хүүхдийн эрхийг хамгаалах бүхий л арга хэмжээг багтаасан байна.

Боловсролын салбарын үйл ажиллагаатай холбоотой сурагчид болон эцэг, эх, асран хамгаалагчдаас дараах асуулгыг асууж, дүн шинжилгээг хийв.

Асуулгын нэгтгэл дүнгээс харахад, багш нараас Хүүхэд хамгааллын тухай хуулийг сурталчлах, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг 53.3 хувь нь жилд 1-ээс доошгүй удаа, 26.6 хувь нь жилд 2-оос доошгүй удаа **ЗОХИОН БАЙГУУЛДАГ** гэсэн ч эцэг эх, асран хамгаалагчдын 63.5 хувь нь **ЗОХИОН БАЙГУУЛДАГГҮЙ** (үгүй, мэдэхгүй хариултын нийлбэр) гэж хариулсан нь хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь өргөн цар хүрээг хамрахгүй байгааг харуулж байна.

Багш нарын 64 хувь нь хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаар эсхүл эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар ирүүлсэн мэдээ, мэдээллийг нийгмийн ажилтантай

хамтран шийдвэрлэж байна. Мөн 4 сурагч тутмын 1 нь хуулийг сурталчилж, таниулах арга хэмжээний талаарх мэдээлэл байхгүйгээс гадна урьдчилан сэргийлэх арга хэмжээнд **ХАМРАГДААГҮЙ** гэсэн хариуг ирүүлсэн. Энэ нь сургалтын орчинд нийгмийн ажилтнаас гадна сэтгэл зүйч бусад мэргэжлийн байгууллага болон мэргэжилтний оролцоо дутмаг байгааг харуулж байна.

3. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЖУРАМД ХУВЬ ХҮНИЙ НУУЦЫН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН ТАЛААРХ ЗААЛТ НЬ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХОЛБОГДОХ ЗААЛТТАЙ НИЙЦЭХГҮЙ БАЙНА.

Орон нутгийн эрүүл салбарын байгууллагуудаас 2019-2023 онд эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлсэн хүүхдийн тоо, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хүүхдийн, түүний гэр бүл, хувийн нууцад хамаарах мэдээллийг хуулиар зөвшөөрсөн этгээдэд мэдээлсэн тоо дараах байдалтай байна.

Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхдээ олж авсан мэдээллийг шаардлагатай тохиолдолд аймгийн Цагдаагийн газар, бусад тохиолдолд аймгийн ХГБХХГ болон багийн хамтарсан багт мэдээлж ажиллаж байна.

Эрүүл мэндийн ажилтан ажил, үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн хувийн нууцын талаар бусдад дэлгэж, нууцыг хадгалаагүй тохиолдол гарч байсан уу гэсэн асуултад нийт сурагчдын 9.1 хувь (79 сурагч) нь **ТИЙМ** гэж хариулсан байна.

Эрсдэлт нөхцөлд орсон үед эрүүл мэндийн байгууллагаас тусламж, үйлчилгээг түргэн, шуурхай, хүртээмжтэй хүргэж байсан эсэх асуултад 22.3 хувь нь (тохиолдол гарсан хүүхдийн хувьд) **ҮГҮЙ** гэж хариулсан байна. Энэ нь эрсдэлт нөхцөлд орсон хүүхдэд хамтарсан баг хариу үйлчилгээ үзүүлэхдээ **ШААРДЛАГАТАЙ ТОХИОЛДОЛД** эрүүл мэндийн ажилтан оролцуулдгаас шалтгаалсан байна.

Эрүүл мэндийн сайдын 2023 оны 240 дүгээр тушаалаар “Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.6-т “Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан бүр хүүхдийн аюулгүй байдлыг хянан хүүхдийн эсрэг хүчирхийллийн шинж байдлыг илрүүлэх, хүүхдийн эсрэг аливаа хүчирхийлэл, мөлжлөг, хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийг зөрчсөн, зөрчсөн байж болзошгүй үйлдлийн талаар байгууллагын удирдлага, **ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖИЛТАН, ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛ**, шаардлагатай бол хүүхдийн тусламжийн утас 108 болон цагдаагийн байгууллагад заавал мэдээлэх, хариу арга хэмжээг цаг алдалгүй авах, шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах” гэж заасан нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хүүхдийн, түүний гэр бүл, хувийн нууцад хамаарах мэдээллийг хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд байгууллага, албан тушаалтан, хувь хүнд мэдээлэхийг хориглох бөгөөд задруулснаас үүдэн гарах үр дагаврыг өөрөө хариуцна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

4. ЦАХИМ ОРЧИНД ХҮҮХДИЙН НЭР ХҮНДЭД ХАЛДСАН ЗӨРЧИЛ АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗАР БҮРТГЭГДЭЭГҮЙ БАЙНА.

Олон нийтийн сүлжээн дэх фэйсбүүк цахим хуудсанд хүүхдийн нэр хүндэд халдсан зөрчил аймгийн Цагдаагийн газар **БҮРТГЭГДЭЭГҮЙ** байна. Цагдаагийн газраас жилд хэд хэдэн удаа аян болон нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулдаг бөгөөд уг арга хэмжээний төлөвлөгөөнд цахим орчны хүүхэд хамгааллын арга хэмжээг багтаан ажилладаг байна. Жишээлбэл: 2023 оны “Хичээл эхэллээ” арга хэмжээний хүрээнд иргэдийн хандалт ихтэй 30-80 группт садар самуун болон мансууруулах бодис сурталчлах, хүүхдийн хөгжил, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөөтэй зураг, кино, дүрс бичлэг болон мэдээ, мэдээлэл оруулах зэрэг хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Сурагчдаас сонин хэвлэл, телевиз, цахим сүлжээ ашиглаж хувийн нууцад халдаж дуу, дүрсний бичвэр, гэрэл зураг тараасан тохиолдол гарч байсан уу? гэх асуултад 8.6 хувь

буюу 75 хүүхэд **ТИЙМ** гэж хариулсан нь цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх технологи ашигладаггүйтэй холбоотой байна.

5. ХҮҮХДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДЭЖ БУЙ НӨХЦӨЛИЙН ДИЙЛЭНХ НЬ ГУДАМЖ ТАЛБАЙ, ОЛОН НИЙТИЙН ГАЗАР ТОХИОЛДОЖ БАЙНА.

Аймгийн Соёл урлагийн газар болон Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас тус заалтын дагуу хийсэн ажил болон дээд байгууллагадаа хүргүүлсэн тайлан байхгүй байна.

Аймгийн Цагдаагийн газрын хүүхдийн эсрэг гэмт хэргийн статистик мэдээнээс харахад нийт хүүхдийн эсрэг гэмт хэргийн 73.7 хувь нь олон нийтийн газар, замын хөдөлгөөн болон гудамж талбайд тохиолдсон байна. Энэ нь эцэг, эхийн хараа хяналт сул, орон нутгийн гудамж талбай, олон нийтийн газрын гэрэлтүүлэг, хяналтын камер хангалтгүй бус, стандарт шаардлага хангаагүй, жолооч замын хөдөлгөөний дүрмийг дагаж мөрддөггүй зэргээс шалтгаалж байна гэж мэргэжлийн байгууллага тодорхойлсон байна.

Харин хүүхдийн тусламжийн 108 дуудлагын утсанд олон нийтийн арга хэмжээ орчны байдлаар нийт 66 дуудлага бүртгэгдсэн боловч дуудлагын талаар тодруулахад олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээ дэх хүүхдийн эрх зөрчсөн мэдээлэл байхгүй байна.

Дорноговь аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар 254 унаач хүүхэд мэдээллийн санд бүртгэлтэй байгаа бөгөөд аймгийн ХГБХХГ-аас унаач хүүхдийн хамгаалалтын хувцасны стандарт, чанарт хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

6. АЙМГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ МЭРГЭЖЛИЙН АНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТАЛЖ, ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАЖ БАЙНА.

Аймгийн ХГБХХГ нь Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг онцгой байдлын газраас арга зүйн туслалцаа авч, 2022 онд боловсруулан баталсан байна. Тус төлөвлөгөөнд гамшгийн өмнөх урьдчилан сэргийлэх, нөхцөл байдлыг тогтворжуулах, сэргээн босгох чиглэлээр 15 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр баталсан.

Сургалтын байгууллага нь суралцагчдаас цахимаар суралцах боломжтой эсэх судалгааг авч, теле хичээлээр дамжуулан сургалтын үйлчилгээг тасалдуулахгүйгээр хүргэж, эцэг, эх, асран хамгаалагчдаар дамжуулан хяналтыг гүйцэтгэж ажилласан байна. Мөн холбогдох газруудад тогтмол мэдээллийг хүргүүлж ажиллажээ.

3.3. ОРОН НУТАГТ МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ ТОГТВОРЖООГҮЙ, МЭРГЭЖЛИЙН БОЛОВСОН ХҮЧИН ДУТАГДАЛТАЙ ЗЭРГЭЭС ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА БҮРЭН ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖИХГҮЙ БАЙНА.

1. НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцын 5 дугаар тайланд өгсөн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг аймгийн ХГБХХГ-аас 2021 оны I улирлын байдлаар харьяалах дээд байгууллагад 41 арга хэмжээнээс 31 арга хэмжээний хэрэгжилтийг сүүлийн 2 жилийн статистик мэдээллийн хамт хүргүүлэн ажиллажээ.

2. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 11 дүгээр зүйлд “Мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах” тухай заасан.

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээ нь зөвхөн дуудлага хэлбэрээр үйлчилгээ үзүүлдэг байсан бол 2021 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс “МЕССЕЖ” хүлээн авах, илгээх үйлчилгээг нэвтрүүлсэн байна.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирүүлсэн дуудлагыг харьяалах нутаг дэвсгэрээр нь хуваарилдаг бөгөөд 2019-2023 онуудад аймгийн хэмжээнд нийт 460 дуудлагыг хүлээн авч шийдвэрлэсэн. Тусламжийн дуудлагын бүртгэл жилд дунджаар 15.5 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь хүүхдүүд тус дуудлагын утасны талаар мэдлэг, мэдээлэлтэй болсонтой холбоотой байна.

Нийт дуудлагын 61.1 хувь нь сумдын нийгмийн бодлогын мэргэжилтэн рүү шилжиж, хамтарсан багаар дамжуулан тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. Харин 179 дуудлага (38.9 хувь)-ыг аймгийн ХГБХХГ хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Нийт дуудлагын шийдвэрлэлтийн байдлыг 2022-2023 оноор авч үзвэл, нийт тохиолдлын 64.1 хувьд нь ярилцлага хийх, 29.1 хувьд нь нөхцөл байдлын үнэлгээ хийх, 3.0 хувьд нь хууль зүйн зөвлөгөө өгөх, 2.0 хувийг цагдаагийн байгууллага руу шилжүүлэх, 1.0 хувьд нь сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх зэргээр хариу үйлчилгээг үзүүлсэн байна.

3. Аймгийн хэмжээнд Сайншанд болон Замын-Үүд суманд 2 түр хамгаалах байрыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн үйл ажиллагааг явуулж байгаа бөгөөд эрсдэлт нөхцөлд байгаа, гэмт хэргийн хохирогч болсон нийт 218 хүүхэд болон насанд хүрэгсдэд түр хамгаалах байрны үйлчилгээг үзүүлсэн байна.

Түр хамгаалах 2 байранд сэтгэл зүйч байхгүйгээс хохирогчийн сэтгэл зүйн байдал, тулгамдсан асуудлыг тодорхойлж, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, нөхөн сэргээх үйлчилгээ дутагдалтай байна. Мөн ажилтнуудыг хагас жил тутам эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулаагүй байна.

Аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос хяналтад байгаа хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдүүдэд сургалтын үйл ажиллагааг явуулсаар байна. Орон нутгийн хэмжээнд 2019-2023 онуудад хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан нийт давхардсан тоогоор 21 хүүхэд байна. Тэдний дийлэнх нь хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан, бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авч хулгайлсан үндэслэлээр арга хэмжээнд хамрагдсан байна.

4. Хүүхэд хамгааллын мэдээллийн системийн тогтворгүй байдал нь мэдээллийн сан бүрдүүлж, хариу арга хэмжээ авахад хүндрэл учруулж байна.

Аймгийн Цагдаагийн газраас хүүхэд гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирч байгаа шалтгаан нөхцөлийг судлан дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

1. Насанд хүрээгүй хүн нь эрх зүйн мэдлэг, боловсрол дутмаг
2. Эцэг, эхийн хараа хяналт сул, мөн тэдний хайхрамжгүй байдлаас шалтгаалан хамаатан садан төрлийн хүмүүс, найз нөхдөд итгэн хүүхдийг үлдээдэг
3. Олон нийтийн газар нь гэрэлтүүлэг, хяналтын камер хангалттай бус, стандарт шаардлага хангадаггүй

Дээрх шалтгаан нөхцөлөөс зайлсхийх замаар жил бүр урьдчилан сэргийлэх ажлыг мөн зохион байгуулж байна. Жишээлбэл, аймгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргийн үзүүлэлт, үйлдэгдэж байгаа шалтгаан нөхцөлийг тусгасан танилцуулгыг аймгийн Засаг дарга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хүргүүлж, “Хайр нэмье-Хүчирхийлэл хасъя”, “Тэвчье-Цэглэе” зэрэг аян, нөлөөллийн арга хэмжээг 2021 онд зохион байгуулсан байна. Мөн 14 сумын хамтарсан багийн албан хаагч, ерөнхий боловсролын 22 сургуулийн нийгмийн ажилтан нартай хамтран нийтийн эргүүлийг зохион байгуулжээ.

Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд өртөж, хохирохоос урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, нөхцөл байдалд амьдардаг хүүхдийг илрүүлэх чиглэлээр улсын хэмжээнд 2022 онд “Хүүхэд хамгаалал” арга хэмжээг зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд “Нэг бүрчилсэн хяналт”-ыг аймгийн Цагдаагийн газраас сумдын нутаг дэвсгэрт зохион байгуулж ажиллажээ.

Хүүхдийн хамгааллын талаарх мэдээллийг 2019-2021 онуудад ABLE системээр, 2022-2023 онуудад НАМС-ээр, (дахин нэвтрэх боломжгүй бөгөөд тус онуудын мэдээллийн сан байхгүй) 2024 онд дахин ABLE системээр дамжуулан сан бүрдүүлсэн байна.

ABLE мэдээллийн системд эрсдэлт нөхцөлд байгаа, уралдаанч хүүхэд болон хүүхдийн зуслангийн мэдээллийг байршуулж байна. Одоогийн байдлаар аймгийн ХГБХХГ-ийн мэдээллийн системд 659 эрсдэлтэй хүүхэд, уралдаанч хүүхдийн нийт 728 мэдээллийг байршуулсан байна.

Мэдээллийн системийн тогтворгүй байдал нь суурь шалтгааныг судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах мэдээллийн суурь бүрдүүлэхэд хүндрэл учруулж байна. Иймээс мэдээллийн сангийн баазыг найдвартай бий болгож, тогтвортой ашиглах шаардлагатай байна.

Энэхүү мэдээллийн системд хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд оролцогч байгууллагууд хариу үйлчилгээнээс эхлэн бүх мэдээллийг дамжуулснаар тэдгээрийн хамтын ажиллагаа ч сайжрах боломжтой юм.

5. Салбар бүр хүүхдийн хамгааллын статистик үзүүлэлтүүдийг харьяа дээд газартаа хүргүүлэн ажиллаж байна.

Хүүхдийн эрх, хамгааллын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал-ыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Нийгмийн статистикийн газарт даалгасан байна. Уг аргачлалын дагуу салбар бүр үзүүлэлтүүдийг тооцох аргачлалыг баталсан байна.

Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын чиглэлийн статистик үзүүлэлтийг Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дүгээр тушаалын II хавсралтаар батлагдсан журмын хугацаанд, XI хавсралтаар батлагдсан аргачлалын дагуу бэлтгэн хүргүүлж байна.

Боловсрол, шинжлэх ухаан яамнаас “Бага, дунд боловсролын анхан шатны статистикийн маягтыг нөхөх заавар”-ыг 2022 онд баталж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Аймгийн ХГБХХГ-аас статистик мэдээг Үндэсний статистикийн хорооноос батлагдсан маягтын дагуу бэлтгэн харьяа дээд байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.

Салбар бүрийн хувьд эрсдэлт бүлгийн тоон мэдээлэл гаргах суурь өөр өөр байх тул мэдээллийн хувьд зөрүүтэй байна.

Эдгээр тоон үзүүлэлтүүд нь хүүхдийн эрх, хамгаалалтай холбоотой бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх суурь мэдээлэл болохоос гадна цаашдын төлөвлөлтөд чухал ач холбогдолтой юм.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Хүүхэд хамгааллын талаарх аймгийн бодлогын баримт бичгийг Монгол Улсын урт, дунд, богино хугацааны баримт бичигтэй уялдуулан арга хэмжээнүүдийг бүрэн тусгаж хэрэгжүүлэн ажилласан байна
- Аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын талаар бодлого боловсруулан хэрэгжүүлж байгаа боловч Хүүхдийн төлөө зөвлөл орон нутгийн бодлоготой уялдуулан үйл ажиллагааг төлөвлөж, тайлагнах, хяналт тавих ажил хангалтгүй байгаагаас хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар төрийн захиргааны байгууллагад чиглэл, холбогдох бусад байгууллагад зөвлөмж өгөх, нутгийн өөрөө удирдах байгууллага болон бодлого тодорхойлох, шийдвэр гаргах эрх бүхий оролцогч талуудад санал оруулах ажлууд хэрэгжихгүй байна.
- Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага хүүхэд хамгааллын талаар нийгмийн ажилтан, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэгчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.
- Аймгийн ХГБХХГ нь дээд байгууллагадаа хүргүүлсэн эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоон мэдээллээс аймгийн хамтарсан багуудын хүүхдийн нөхцөл байдлын үнэлгээгээр гаргасан мэдээнээс зөрүүтэй байгаа нь холбогдох байгууллагын хариуцлагагүй байдлаас шалтгаалсан байна.
- ХГБХХГ-ын салбарын хэмжээнд хүүхэд хамгааллын талаарх үйл ажиллагааны мэдээллийн систем нь тогтворжоогүй, үүсгэсэн мэдээллээ цаашид ашиглах боломжгүй болсон зэргээс харахад аймаг, орон нутаг, улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх шаардлагатай байна.
- Орон нутагт сэтгэл зүйч болон нийгмийн ажилтан дутагдалтайгаас хүүхэд хамгааллын үйлчилгээг цогцоор нь үзүүлж, хүүхдийн эрх зөрчигдөх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж чадахгүй байна.
- Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын төсвийн төслийг аймгийн эрсдэлд бүлгийн хүүхдийн тоо, өмнөх онд хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулсан хүүхдийн тоо, хэрэгжүүлсэн арга хэмжээ зэрэг бодит тоон мэдээлэл, судалгаанд үндэслэн төлөвлөдөггүй байна.
- Аймгийн ХГБХХГ-ын батлагдсан төсөвт хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих зардлын хөтөлбөр тусдаа баталдаггүй, урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардлаас санхүүжүүлж байгаа нь нийтийг хамарсан урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулахад дутмаг байна.
- Аймгийн ХГБХХГ-т хүүхэд эмэгтэйчүүдийн аюулгүй байдлыг хангах түр хамгаалах байрны үйл ажиллагааг тасралтгүй явуулах зорилгоор шаардлагатай санхүүжилтийг жил бүр аймгийн орон нутгийн төсөвт тусган бүрэн санхүүжүүлэн ажилласан байна.
- Аймгийн ХГБХХГ-ын 2019-2023 онд хүүхэд хамгааллын хөтөлбөр арга хэмжээний зардалд улс, орон нутгийн төсвөөс нийт 588.8 сая төгрөгийг зарцуулснаас 29.6 хувийг түр хамгаалах байрны үйл ажиллагаанд, 1.2 хувийг эрсдэл болон нөхцөл байдлын үнэлгээ хийх зардалд, 11.9 хувийг урьдчилан сэргийлэх, 57.3 хувийг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд тус тус зарцуулсан байна.
- Шилэн дансны цахим хуудсанд хүүхэд хамгааллын зардалтай холбоотой 2019-2023 онуудад нийт 554.1 сая төгрөгийн мэдээллийг цаг хугацаанд нь ил тод хангалттай тайлагнаагүй байна.
- Аймгийн ХГБХХГ нь өөрийн байгууллагад мөрдөх байгууллагын нууцын журам боловсруул батлаагүйгээс хувь хүний мэдээллийн хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна.
- Аймгийн ХГБХХГ нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18.2.3, 22.1 заасны дагуу тус хуулийн хэрэгжилт болон хүүхэд хамгааллын нөхцөл байдлыг тодорхойлох, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх хариу үйлчилгээг үнэлэх чиглэлээр хяналт, шинжилгээ, үнэлгээг хийгээгүй байна.

- Хүүхэд хамгааллын талаар салбар бүр тодорхой арга хэмжээ хэрэгжүүлж байгаа боловч өргөн цар хүрээг хамарч чадахгүй байгаа аймгийн ХГБХХГ нь төрийн байгууллага, хуулийн этгээдийн хүүхдийн асуудал хариуцсан ажилтан, алба хаагчдыг сургах, мэргэшүүлэх, нийгмийн ажилтан, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэгчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үйл ажиллагааг явуулдаггүйтэй холбоотой байна.
- Эрүүл мэндийн салбарын хүүхэд хамгааллын журамд хувь хүний нууцын хадгалалт, хамгаалалтын талаарх заалт нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн холбогдох заалттай нийцэхгүй байна.
- Аймгийн ХГБХХГ-аас Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журмын хэрэгжилтийг хангах хяналт тавьсан талаар дээд байгууллагадаа тайлагнаагүй байна.
- Аймгийн ХГБХХГ нь 2022 онд Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг баталсан.

Аудитаар Үндэсний аудитын газарт 3 санал хүргүүлж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд 8 зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ НЬ:

1. Эрүүл мэндийн сайдын 2023 оны 240 дүгээр тушаалаар “Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын журам”-ын 3.1.6 дахь заалт нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 17 дугаар зүйл, 24.4-д заасантай нийцэхгүй байх тул тус журмын заалтыг хуульд нийцүүлэх талаар,
2. Аймгийн ХГБХХГ-ын төсөвт хүүхдийн хөгжил, оролцоо гэсэн хөтөлбөр арга хэмжээний зардлыг хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлуудаас салгаж тусад нь батлуулах талаар,
3. ХГБХХГ-ын салбарын хэмжээнд мэдээллийн нэгдсэн санг бий болгох талаар тус тус холбогдох байгууллага албан тушаалтанд уламжилж өгнө үү.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

**АЙМГИЙН ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА О.БАТЖАРГАЛ ТАНАА:**

1. Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл Хүүхэд хамгааллын тухай (Шинэчилсэн найруулга) хуулийн 37.2, 38.1.2, 38.1.3 заалтыг хэрэгжүүлж ажиллах
2. Орон нутгийн хэмжээнд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн боловсон хүчний нөөц бүрдүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах

**АЙМГИЙН ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ГАЗРЫН
ДАРГА Ш.АЛИМАА ТАНАА:**

1. Хүүхэд хамгааллын тухай (Шинэчилсэн найруулга) хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6-т заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, түүний гэр бүлд үзүүлсэн хүүхэд хамгааллын үйлчилгээний талаар нэгдсэн бүртгэл, судалгаа хөтөлж, хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн санд бодитой үнэн зөв тоог нэгтгүүлэх, хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.1-т орон нутаг, анхан шатны нэгжээс эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар бүртгэл, судалгааг авч нэгтгэн дүгнэх гэж заасны дагуу үнэн зөв бодит тоо мэдээг гаргаж, мэдээлж байх
2. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын төсвийг тоон мэдээлэл, судалгаанд үндэслэлтэй төлөвлөх
3. Байгууллагад мөрдөх байгууллагын нууцын журамд хувь хүний мэдээллийг хадгалах, хамгаалах, хариуцлагын үйл ажиллагааг тодорхойлон тусгаж боловсруулан батлан, мөрдөн ажиллах
4. Хүүхэд хамгааллын тухай (Шинэчилсэн найруулга) хуулийн 53 дугаар зүйлд хүүхэд хамгааллын нөхцөл байдлыг тодорхойлох, хүүхэд хамгааллын үйлчилгээг үнэлэх зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах
5. Хүүхэд хамгааллын тухай (Шинэчилсэн найруулга) хуульд Аймаг, нийслэл, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхэд хамгааллын асуудлаар 35 дугаар зүйлийн 35.1.2-т “хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлэх”, 35.1.11-д “төрийн байгууллага, шүүх, прокурор, хууль сахиулах байгууллага, хуулийн этгээдийн ажилтан, албан хаагчийг хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах”, 50 дугаар зүйлийн 50.1.5-д “хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын албан хаагч, хүүхэд, гэр бүлийн болон бусад салбарын нийгмийн ажилтантай ганцаарчилсан болон хамтарсан уулзалт, ярилцлагыг зохион байгуулж, зөвлөмж, зөвлөгөө өгөх”, 51 дүгээр зүйлийн 51.1-д “Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага хүүхэд хамгааллын үйлчилгээг мэргэжлийн удирдлагаар хангах 6 чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлэн ажиллах
6. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга, Соёл урлагийн газрын даргын 2022 оны А/242, А/76 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам”-ын 5 дугаар бүлгийн 5.1-т “Тухайн орон нутгийн хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ